



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/179

Баруун-Урт сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруун-Урт сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Н.Эрдэнэцогт захиралтай "Марс-Ундрал" ХХК-ийн "Монмарс" хүнсний дэлгүүр, Сүхбаатар сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Б.Хандсүрэн захиралтай "Бишрэлт тулга" ХХК-ийн "Дарханхаан" хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай сунгаж, Баруун-Урт сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Очирбат захиралтай "Тотал дистрибьюшин" ХХК-ийн "Тотал" агуулах худалдаа, Түмэнцогт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй М.Жаргалмаа захиралтай "Тод түмэн" ХХК-ийн "24" хүнсний дэлгүүрт согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл сунгагдсан болон шинээр олгогдсон аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Гантулга), Мэргэжлийн хяналтын газар (О.Балжинням), Стандарт хэмжил зүйн хэлтэс (Д.Эрдэнэбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг дээрх аж ахуй нэгжүүдийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ

2222010367